

“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН  
2023 ОНЫ 2 ДУГААР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023.03.03

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

“ГТХЗНТ” УТУГ-ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн батлуулсан нэгжүүдийн 2 дугаар сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлага, ажилтнуудыг мэдээллээр хангаж, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал**

Нэгжүүдийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөөнд урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулж хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалаар үнэлэв.

**Үнэлэлт**

Нэгжүүдийн сарын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтээр үзүүлэв.

Нэгжийн нэр	Төлөвлөсөн ажил	Үүнээс							Биелэлт /хувиар/
		100%	90%	70%	50%	30%	0%	ХБ	
ЗСХ	14	9	-	3	1	1	-	-	85.0
ТНУАСХ	10	9	-	-	-	1	-	-	93.0
ГХБАБМХ	11	9	-	2	-	-	-	-	94.5
<b>Дүн</b>	<b>35</b>	<b>27</b>	<b>-</b>	<b>5</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>90.2</b>

**Дүгнэлт:**

1. Тайлант сард ЗСХ 14, ТНУАСХ 10, ГХБАБМХ 11, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд нийт 35 ажлыг төлөвлөсөж, 90.2 хувийн хэрэгжилттэй байгаа нь өмнөх сартай харьцуулахад +0.5 хувиар өссөн дүнтэй байна.

2. ЗСХ-ийн сарын ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 85.0 хувьтай, өмнөх сартай харьцуулахад +6.2 хувиар өссөн, ТНУАСХ-ийн төлөвлөгөөний хэрэгжилт 93.0 хувьтай, өмнөх сартай харьцуулахад -4.7 хувиар буурсан, ГХБАБМХ-ийн төлөвлөгөөний хэрэгжилт 94.5 хувьтай, өмнөх сартай харьцуулахад -5.5 хувиар буурсан дүнтэй байна.

3. Төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулж нэгжүүдийн төлөвлөсөн ажлуудаас “Ажилтнуудын орон сууцны барилгын архитектур төлөвлөлтийн даалгаврыг батлуулах асуудлаар төрийн болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах”, “Төвийн баримт нягтлан шалгах комиссыг шинэчлэн байгуулж, комиссыг хуралдуулах”, “Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилга барих төслийг үргэлжлүүлэх” гэсэн ажлууд тодорхой үр дүнд хүрээгүй байна.

#### Санал зөвлөмж:

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023.02.27-ны өдрийн 4-р шуурхай хуралдаанаас “Зам, тээврийн салбарыг 2023 онд бүрэн цахимжсан, **бүтээмж хариуцлагыг нэмэгдүүлж, үр дүнг тооцох жил**” болгон зарласантай холбогдуулан **гүйцэтгэлийн төлөвлөгөөг сар бүр дүгнэж ажиллах** үүрэг даалгавар өгөгдсөн бөгөөд ажилтнууд төвийн болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэй уялдуулж сарын ажлыг төлөвлөж, хүрэх үр дүнг тодорхой тусгаж байх.

2. Нэгжүүд зарим ажлын үр дүнг “Хийж гүйцэтгэсэн байна”, “Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтот ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн байна”, “Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хийж гүйцэтгэсэн байна”, “Төлөвлөгөөт ажлыг хийж гүйцэтгэсэн байна” гэх зэргээр “хүрэх түвшин”-г ерөнхий байдлаар тодорхойлсон төлөвлөлтийн алдааг засаж, сайжруулах.

3. Зарим ажлын биелэлтийг хэт товч, тодорхойгүй тайлагнаж байгаа тул төлөвлөгөөний тайлан биелэлтийг гаргахдаа “хүрэх түвшин”-тэй уялдуулж тодорхой тайлагнах.

4. Төвийн дотоод үйл ажиллагаатай холбоотой туслах чанараар баталсан ХАБЭА, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, захирлын зөвлөлөөр хэлэлцүүлэх асуудлын, гадаад арга хэмжээний, албан даалгавар хэрэгжүүлэх тухай төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжилтийг хангах.

5. Өмнөх сарын хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгагдсан санал зөвлөмжийг хэрэгжүүлэх.

6. ЗТХЯ-наас ирүүлсэн хариутай албан бичгийг хугацаанд шийдвэрлэж хариуг хүргүүлэх.

#### ТАНИЛЦСАН:

“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗАХИРАЛ

А.БУЯННЭМЭХ

ТНУАСХ-ИЙН ДАРГА

Д.ТӨГСЖАРГАЛ

ГХБАБМХ-ИЙН ДАРГА

Ц.ОЮУНБАТ

**БОЛОВСРУУЛСАН:**  
ХШҮМ

*Э.Осоржамбаа*

Э.ОСОРЖАМАА